



ХЭНТИЙ АЙМАГ
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/35

Бор-Өндөр


Засаг даргын нөөцөөс хөрөнгө
зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэхь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.20 дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр Тушаалын хавсралтаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.6 дахь хэсгийн тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Билгийн тооллын 17 дугаар жарны "Элдэв эрдэнэт" хэмээгч Модон могой жилийн сар шинийн баярыг угтан бөхийн барилдааны бай шагналд 2,648,000 (хоёр сая зургаан зуун дөчин найман мянга) төгрөг, Сумын аварга малчин, сумын аварга тариаланчийн зардалд 570,000 (таван зуун далан мянга) төгрөг, Оны есөн алдартан шалгаруулахад 1,500,000 (нэг сая таван зуун мянга) төгрөг, нийтийн золголтын арга хэмжээний зардалд 1,575,000 (нэг сая таван зуун далан таван мянга) төгрөг нийт 6,293,000 (зургаан сая хоёр зуун ерэн гурван мянга) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Зардалд шаардагдах 6,293,000 (зургаан сая хоёр зуун ерэн гурван мянга) төгрөгийг зохих хууль дүрэм, журмын дагуу Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (О.Мөнхцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ